



**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН 2017
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.12.15

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ-ОНӨТҮГ-ЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

1.1 Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц

1.1.1 Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана.

- Сүүний чиглэлийн үнээний загвар ферм барих ажлыг тендерт шалгарсан Сайн констракшн компани барьж дуусган, улсын комисст 12 сарын 24- ний өдөр хүлээлгэн өгсөн. Нийслэлийн засаг даргын А-873 тоот захирамжийн дагуу хотын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс гаргасан үнээнээс 30 ширхэг тугалтай үнээг сонгон авч, фермд байрлуулан маллагаа явуулж байна. Эдгээр үнээнд зориулан 50 тонн байгалын хадлан бэлтгэж, 13 тонн хэвэг худалдан авч, нийлүүлэн өвлийн бэлтгэл ажлыг хангаад байна.



1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

1.2.1 Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.

1.2.1.1 "Бэлчээрийн менежемент" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн ХАА-н техник, тоног төхөөрөмжийн угсралт, тохиргоо, засвар үйлчилгээ болон хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

- Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 110 морины хүчтэй Нью Холланд маркийн тракторын хөдөлгүүрийн зүгшрүүлэлт, тохиргооны ажлыг гүйцэтгэж, 300 мот.цаг явсны дараа

Нийлүүлэгч компани Энсадагаас мэргэжлийн хүмүүсийг ирүүлэн, техникийн үйлчилгээ хийлгэсэн. Мөн бууц цацагч, бордоо цацагч болон үрлэгч машиныг ажиллуулан, туршилт тохируулгын ажлыг дээрхи компанийн мэргэжилтнүүдтэй хамтран 6 дугаар сард амжилттай зохион байгуулсан.



- Мөн тракторын хөдөлгүүрийг зүгшрүүлэх, ажлын ачаалалд оруулах зорилгоор нийт 100 орчим га талбайд газар хагалж, 150 га-д хүнд диск, хөрс сийрүүлэгч суурьлуулан, хөрс боловсруулалтын ажил хийж, өдөр тутмын техникийн үйлчилгээг тогтмол хийж, гүйцэтгэсэн.



- Өтөг бууц цацагчийг турших, тохируулах зорилгоор нийт 4 га талбайд, бордоо цацагчийн ажиллагааг тогтворжуулах, тохируулах зорилгоор нийт 80 гаруй га талбайд бордоо цацаж туршилтын ажлыг амжилттай зохион байгуулсан.
- Хадуур, тармуур, өвс хуйлагчийн ажиллагааг турших, зүгшрүүлэх зорилгоор нийт 100 га газар өвс хадаж, 50 тонн хадлан бэлтгэсэн.



Хоёр. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Манай байгууллагад тусгайлан заасан тогтоол шийдвэр байхгүй

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

3.1 Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

3.1.1 Бэлчээрийн талбайг хагалахгүй, харсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нэвтрүүлэх

- Guettler маркийн үрлэгчийн ажиллагааг тогтворжуулах, тохиргоо хийх зорилгоор туршилтын талбайн 10 га-д БНХАУ-аас нийлүүлсэн олон наст ургамалын үрээр үрсэлгээ хийж туршилт явуулсан. Харин Австри улсын 2 төрлийн, 8 зүйлийн 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог үрээр батлагдсан технологийн картын дагуу тариалалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байсан боловч хавар, зуны улиралд хуурайшилт ихтэй, бороо орохгүй гандуу байсныг харгалзан, Австри улсын мэргэжилтэн Бүхграберын зөвлөсний дагуу тариалалтын ажлыг бүтэн жилээр хойшлуулах шаардлагатай болсон. Олон наст үрийн холимог худалдан авах хөрөнгийн асуудлыг ХХААЯ-нд хандаж шийдвэрлэсэн бөгөөд 2018 онд Австри улсаас нийлүүлэхээр төлөвлөж байна.





3.1.2 Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх,.

3.1.3 Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх,

3.1.4 Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх,

- Дээрхи заалтууд нь Австри улсаас нийлүүлэгдэх үрийн холимог нийлэгдээгүй хойшлогдсоноос шалтгаалан, тасарсан.

3.1.5 Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулах

- Сайн констракшн компани Эрчимжсэн мал аж ахуйн загвар компанийг барьж дуусган, улсын комисст 2017 оны 12 сарын 24- ний өдөр байнгын ажиллагаанд оруулахаар хүлээлгэн өгсөн. Цаашид автомат саалтуур суурилуулах, шивх зайлуулах бункерийг ашиглалтанд оруулах, сургалтын төвийн тавилга хэрэгслийг нийлүүлэх зэрэг загвар аж ахуйн үйл ажиллагааг улам боловсронгуй болгож, тогтмолжуулах ажлууд үе шаттайгаар хийгдэнэ.



3.2 Хүний нөөцийг чадавхижуулах

- Тайлангийн хугацаанд механик болон операторууд Енсада компаниас зохион байгуулсан 5 удаагийн сургалтанд хамрагдаж, тухайн тоног төхөөрөмж дээр хэрхэн ажиллах талаар дадлага туршлага олж авсан.
- Мөн Хүний нөөцийн мэргэжилтэн Архивийн газар болон Мэдээлэл технологийн газраас зохион байгуулсан сургалтанд , Нягтлан бодогч Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сургалтанд тус тус хамрагдсан.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

- Иргэн Э.Халиун Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн гэж нэхэмжлэл гаргасан. Э.Халиун нь тус байгууллагад Мэргэжилтэн туслахаар 2016 оны 10 дугаар сарын 05-аас 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл ажиллаж байсан. Уг иргэний нэхэмжлэлтэй холбоотойгоор Мэргэжилтэн туслах А.Гэрэлтуяа нь 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хуралдаан, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хуралдаанд тус тус байгууллагаа төлөөлж оролцсон. Дээрх 2 шатны шүүхээс иргэн Э.Халиуны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гарсан.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын веб сайт, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, холбогдох мэдээллийг байрлуулан ажиллаж байна.	90
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн мэргэжилтэн А.Гэрэлтуяа хариуцан, иргэдтэй уулзах цагийн хуваарийг мэдээллийн самбартаа байрлуулж ажилладаг.	70
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Шинээр нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжүүдийг ашиглан хамтран ажиллах хүсэлт тавьсан аж ахуйн нэгж, иргэдийн захиалгын дагуу зарим нэг газар тариалангийн үйлчилгээг төлбөртэйгээр хийж гүйцэтгэх талаар мэдээллийн самбар, байгууллагын брошур, танилцуулга дээр байрлуулж мэдээлэл хүргэдэг	70
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг цахим хуудас болон, мэдээллийн самбартаа байрлуулж, тухай бүр нь шинэчилдэг.	100
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	-	
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион	-	

	байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;		
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	-	
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-	
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаархи мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан ажиллаж байна.	90
Хэсгийн дундаж хувь:			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Сул орон тооны зарыг мэдээллийн самбартаа байрлуулж, ХААИС гэх мэт мэргэжлийн байгууллагад хүний нөөцийн талаар санал тавьж, ажилласан.	50
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн Ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж, мэдээллийн самбарт байрлуулан тухай бүр шинэчилдэг.	90
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-	
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	-	
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга	Ажлын үр дүнгийн шагнал урамшуулал олгох, Ур чадварын	70

	болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	нэмэгдэл олгох журмыг боловсруулан даргын тушаалаар батлуулсаны дагуу дүгнэж, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна.	
Хэсгийн дундаж хувь:			

Тав. Бусад

5.1 Төслийн хүрээнд шинээр нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжийн ажиллах чадвар, хүчин чадал, давуу тал болон Бэлчээрийн менежемент төслийн ач холбогдол, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ХААИС-ын 60 орчим багш, оюутнуудыг оролцуулан, төсөл хэрэгжүүлж буй Нарийний амны туршилтын талбай дээр сургалт зохион байгуулсан.

5.2 Аж ахуйн үйл ажиллагаа явуулж, нэмэлтээр орлого олох, дараа жилүүдэд тариалалт хийх цэвэр сортын төмсний үртэй болох зорилгоор 1.4 га талбайд хагалгаа, боловсруулалт хийж 3000 кг “Гала” сортын төмсний элит үрээр тариалалт хийсэн.

5.3 Трактор болон бусад ХАА-н тоног төхөөрөмжийг ашиглан иргэн, аж ахуйн нэгжийн захиалгаар 60 га газарт газар хагалах болон сийрэгжүүлэлтийн ажил гүйцэтгэж, 4 га газарт сангас, бууц цацах ажлыг төлбөртэйгээр хийж гүйцэтгэсэн.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЕНЕЖЕР
ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА

/Г.ПҮРЭВСҮРЭН/
/Г.ГАЛДӨЛ/